

МОНГОЛЧУУДЫН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАХ ХҮМҮҮНЛЭГ УЛАМЖЛАЛЫН АСУУДАЛД

*С.Амаржаргал
Судлаач*

Манай орон эх газрын эрс тэс уур амьсгалтай, хоногийн температурын зөрүү 10-20 хэм, улирлынх 80-100 хэм хүрэх бөгөөд нийт нутаг дэвсгэрийг хамарсан ган зуд арван хэдэн жилийн давтамжтай тохиолдох төдийгүй заримдаа зуун жилээр ч үргэлжилсэн их ган зудын тухай түүхэнд тэмдэглэгдсэн бий. Ер нь монгол нутаг уур амьсгал, хөрс ургамал, гадаргын тогтцын хувьд хүний амьдралын тийм ч ая тааламжтай орчин биш юм.

Байгаль цаг уурын ийм эрс тэс хатуу ширүүн нөхцөлтэй арсалдан амьдрахаас өөр хувь тавилан монголчуудад байсангүй. Ингэхдээ бие биендээ харилцан туслалцаж хамтрах замаар л энэ эгэл биш нөхцөл, ер бусын хүчийг сөрөн зогсож тэсч үлдээд дасан зохицож чадах нь тодорхой.

Монголчуудыг харилцан туслалцах харилцаанд түлхэх өөр нэг хүчин зүйл нь тэднийг цөөхүүлээ гэдгийг нь мэдрүүлж, хамтын хүчийг ойлгуулсан нийгмийн хүчин зүйл байв. Эртнээс янагш улс түмний харилцаанд аливаа асуудлыг хүч хэрэглэн шийдвэрлэж ирсэн, тэр хүчээ хүнийхээ тоогоор хэмжиж байсан түүхийн өршөөлгүй сорилт шалгалтаас монголчууд хүний үнэ цэнийг мэдэрч хүнийг хайрлах, түүнд тус дэм болох уужим сэтгэл их ухаарлыг олсон бөлгөө.

Амьдралынх нь оршихуй, хөгжихүйн анхдагч хэрэгцээ эв нэгдлийг буюу хамтын санаа бодолтой байж харилцан туслалцаж дэм дэмэндээ байхыг шаардаж байхад монголчууд түүнээс зөрж, адарч байгаа юм шиг энгүй уудам хээр тал, элчилгүй их говиороо тарж нүүдэллэн амьдарч ирсэн нь сонирхолтой.

Нүүх гэдэг нь тэдний эрхэлдэг мал аж ахуйтай шууд холбоотой нь ойлгомжтой ч хамтрах, харилцан туслалцах хэрэгцээгээ хэрхэн яаж хангаж байв гэдэг нь сонирхолтой юм.

Нүүдлийн амьдрал хар амиа боддог бэртэгчин сэтгэлгээг төрүүлдэг гэх юмуу эсвэл хамтач үзэл санаа, харилцан туслалцах харилцаа гэдгийг зөвхөн нэг дор бөөгнөрсөн хүмүүст бололцоотой зүйл хэмээн төсөөлөх нь өрөөсгөл юм. Энэ нь нүүдэлчний амьдралын зарчим, хэв маягийг мэдэхгүйгээс эсвэл түүнийг суурин иргэншлийн шалгуураар үнэлэх гэснээс үүднэ.

Нүүдэлчдийн харилцан туслалцах харилцаа суурин иргэншлээс өөр, харилцан туслалцагч талуудыг заавал нэг дор, хамтдаа байхыг шаарддаггүйгээрээ л өвөрмөц байдаг. Тэдний хувьд хамт амьдрах, харилцан туслалцах гэдэг нь хоёр өөр агуулгатай юм.

Монголчууд нэн эртний уламжлалаа олон зууны турш алдалгүй хадгалж ураг төрлөөр айлсан /хамтран/ амьдарч ирсэн. Айлсаж амьдрах энэ хэлбэрт харилцан туслалцах гэсэн ойлголт байхгүй. Тэд айл хүний амь нэг гэдэг зарчмаар л амьдарч "ахлагчаасаа эхлээд жирийн иргэд нь хүртэл бүгд мал сүргээ маллан өмч хөрөнгөндөө санаа тавьдаг байв."²⁵¹

Монголчууд бие биедээ харилцан тусалдаг уламжлалыг дан ганц ураг төрлийн хэлхээтэй /овгийн байгууллын уламжлалтай/ холбон үзэж болохгүй. Харилцан туслалцах харилцаанд ураг төрлийн хүрэнээс гадна, таних танихгүй хэнийг ч дэмжиж туслах сайхан сэтгэл хүмүүнлэг ёсыг ихэд эрхэмлэж ирсэн юм.

Гэр орноо эзэнгүй орхихдоо идээ будааны зүйл бэлтгэж үлдээгээд үүд хаалгаа цоожлолгүй явдаг /одоо хүртэл малчдад байдаг/ заншил хэн байх нь хамаагүй ирсэн хүнд л тус дэм болох гэсэн сэтгэлээс өөр юу ч биш. Чухамдаа ийм л хэлбэрээр нүүдэлчин монголчуудын харилцан туслалцах харилцааны өвөрмөц хийгээд хүмүүнлэг чанар илэрдэг. Нүүдэлчдийн ийм харилцаа аливаа тусламж дэмжлэгийг мөнгөн болон материаллаг үнэлгээгүй, хуурамч ёсорхол үгүй болгожээ. (Нөхөрлөл суларсан газар хоосон ёсорхол ихэсдэг гэж аугаа их В.Шекспир хэлсэн гэдэг.)

251 /В.И.Авдиев. история древнего Востока.М.,стр 143.1953/

Тэд хүнд туслах явдлыг үүргээ гэж үзнэ. Харилцааны энэ хэлбэрт аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ гэдэг зарчим л үйлчилнэ. Монголчуудын ийм харилцаа тэдний өөрийгөө үнэлэх "Би"-гийн дүр төрхийг хэзээ ямагт бусдаас хамаармал байдалтай болгосон юм.

Их эзэн богд Чингис хаан мөнх тэнгэрийн хүчээр их эзний суудалд залрахдаа ч, дэлхийн талыг хүлгийн туураар хэмжиж, илдний ирээр хураахдаа ч цэцэн ухаант эх, эрдэмт дүү нар, үнэнч мэргэн өрлөгүүд, зоригт эрсийн хүч, тус дэмэнд дулдуйдсанаа өөрөө ч өчиж, өрөөл нь ч өгүүлсэн байдаг бол эдүгээ хөдөлмөр зүтгэлийнхээ гавьяаг төр засгаараа үнэлүүлэн шагнал хүндлэл хүртэгчид өөрийнхөө ололт амжилтыг хамт олон, бусад хэн нэгтэй заавал холбон үздэг нь гайхах зүйл биш.

Ийн үзвэл тамын тогооны тухай онигоо гэгч монголчуудын төрөлх чанарыг онож илэрхийлсэнгүй. Сайндаа л монголчууд уламжлалт амьдралын хэв маягаасаа холдсон гэж хэлж болох өнгөрсөн зууны сүүлийн хагас дахь нэгэн үеийнхний зарим хэсэгт олдмол байсан араншинг өгүүлсэн биз. Түүнийг нийт монголчуудад хамаатуулж үндэсний шинж болгон ойлгох хэрэггүй. Тэгээд ч ердийн ухамсрын түвшинд дүгнэлт хийгчид өөрийнхөө орчныг, өөрийнхөө цаг үеийг л хардаг юм.

Монголчуудын бие биедээ тусалж дэмжих харилцааны уламжлалыг хүн хүндээ нөмөр нөөлөг болж тусалж дэмждэг байсан гэдгээр хязгаарлавал хэт ерөнхийлсэн хэрэг болно.

Төр болон нийгмийн нийт гишүүдээс онцгой асрамж хүндлэл хүлээдэг социаль бүлгүүд хэзээнээс байсан. Өтгөс буурлууд, нялх балчирраа энэрэн монголчуудын өдөр тутмын амьдралын хэм хэмжээ зан заншил нь болж төлөвшсөн юм. Тиймээс энд элдэв ишлэл татаж, баримт дурьдан батлах гэх шаардлагагүй. Өндөр настанг хүндлэн дээдлэх нь гагцхүү овгийн байгууллын ёс хадгалагдан үлдсэний илрэл гэх нь бас өрөөсгөл.

Овог аймгийн удирдагчид хувийн эр чадал, эрдэм билиг юугаараа тодорч бусдыгаа манлайлан өргөмж хүндлэл хүртдэг байхад, өтгөс буурлууд, нялх балчрууд нас /амьдралын туршлага/ гэдэг социаль шинжээрээ нийгмийн хайр, хүндлэл хүлээж, нийтийн халамж анхааралд багтдаг байв.

Ядуу дорд хүмүүст хандаж байсан хандлагыг бид олон жилийн турш ангич байр сууринаас харж тайлбарласаар тэр төсөөлөл дүгнэлтэндээ бүүр эргэлзээгүйгээр итгэж үнэмшсэн билээ. Гэтэл Оросын их эрдэмтэн Л.Н.Гумилев "Хүн гүрэн" хэмээх зохиолдоо "олзлогдогсод болон дүрвэж ирэгсэдтэй нэн энэрэнгүй харьцана. Иймд хятадууд Хүнчүүдийн уулгалахаас сэргийлэхээсээ өмнө хүн ам нь тал нутаг руу, хүн нарруу байнга шилжиж буйд санаа их зовдог байв" /хуудас 81/ гээд Хүн улсын үеийн хятадын ордны шүлэгч Цэ Юн Юан "Сэтгэлийн дуудлага" гэдэг шүлэгтээ:

"Хойт зүгт хоцорно гэж бүү тэнэглэ

Тэнд уулнаас өндөр мөс овоолгоостой

Тэнд хэдэн зуун ли газар цасан шуурга оволзоно

Тэнгэр газрыг нь дүрсэлнэ гэвэл бүүр ч аюумшигтай" хэмээн хүн амаа ятгах гэж аргаа барж бичсэнийг нь дурьдсан буй: /хуудас 42/

Дүрвэлт гэдэг бол хэзээнээс хүмүүнлэг бус амьдралаас залхсан ядуу дорд хүмүүсийн үйлдэл байсан бөгөөд эндээс **Нэгд:** Эртний монголчуудын нийгмийн амьдрал хүмүүнлэг ялангуяа ядуу дорд хүмүүстэй харилцах харилцаа хятадынхаас лавтайяа илүү хүмүүнлэг байжээ. **Хоёрт:** Монголчууд дүрвэж ирэгсэдэд нэн хүмүүнлэг ханддаг байсан бол элэг нэгт монгол ах дүү нарынхаа ядуу дорд хэсгийг тэднээс доогуур үзэхгүй нь тодорхой гэсэн хоёр зүйлийг хэлж болох юм.

Мэдээжээр нийгэм дэх бүлгүүдийн ялгаа зэрэг дэвд тохирсон статус байсан л биз. Нөгөө талаар тэр үеийн нийгмээс өнөөгийн иргэншил дэх хүмүүнлэг харилцааны хэм хэмжээг шаардах гэвэл бүдүүлэг алдаа болно.

Монголчуудын харилцан туслалцах хүмүүнлэг харилцааны уламжлалаас алдаж эндсэн хүмүүстэй хэрхэн харьцаж байсан нь басхүү сонирхох ёстой зүйл юм. Судлаачид алдаж эндэгсдэд өршөөнгүй ханддаг байсныг тэмдэглэхийн хамт урвалтаас бусад алдааг уучилж болно гэж үздэг, бас алдаа эндлээ засаж залруулах боломж олгодог тухай бичсэн нь бий. Тэр боломж нь сэтгэлзүйн урам дэм өгч итгэл үзүүлэх материаллаг зүйлс /орон гэр барьж, мал тасалж/ өгөхөөс эхлээд зарим үед тодорхой эрх мэдэл олгох зэрэг янз бүрийн хэлбэртэй байсан.

Алдаж эндсэн хүмүүс алдаагаа засах гол талбар нь шийдвэрлэгдээгүй, бэрхшээлтэй асуудлууд, зарим үед амь насаа ч алдаж болох зүйл байдаг байв. Энэ нь нэгдүгээрт тэдэнд итгэл хүлээлгэсний баталгаа, хоёрдугаарт тэднийг сорьж шалгах өвөрмөц арга байлаа.

Алдаж эндсэн хүмүүстэй харилцах харилцаа аль ч үед сэжиглэл болгоомжлолоос ангид байж чадахгүй нь ойлгомжтой ч түүнийг бүүр ил тод болгон, тийм хүмүүсийг ялгаварлахаа бодлого болгон тавьж байсан нь өнгөрсөн зууны эхний хагасаас эхэлсэн боловуу. 1920-иод оноос хүүхэд залуучуудын сайн дурын байгууллага, эвлэл холбоодоос эхлээд төрийн институтыг хүртэл дан ганц шилдэг тэргүүний хүмүүсээр бүрдүүлнэ гэж тунхагласан нь уламжлалаас тасарсан төдийгүй амьдралаас тасарсан зүйл байв. Ийм алдааны ул мөр өнөө болтол нийгмийн сэтгэл зүй, олон түмний санаа бодлоос арилаагүй байна.

Харилцан туслалцах уламжлал дан иргэд хооронд байсан бус иргэн төр хоёрын харилцаанд ч ярих өв уламжлал бий. Иргэн хүн төрөө дээдлэн шүтэж, төрийн сүлдэндээ сүслэн захирагддаг байхад төр нь иргэнээ халамжлан захирдаг байв. Манай төрийн түүхэнд ХХ зууны хэлмэгдүүлэлтийг эс тооцвол /энэ хэлмэгдүүлэлт монгол төрийн сэдэл санаачлагаар бус, гадны шахалт дарамтаар хийгдсэн гэдэг нь тодорхой/ иргэдээ цөхрөөн гомдоож өршөөл, энэрэлгүй хандаж иргэд нь төрийнхөө эсрэг цус урсгасан бослого хөдөлгөөн гаргаж байсан хүйтэн цэвдэг харилцааны баримтыг эрээд олохгүй. Энэ бол төр иргэний харилцаа хүмүүнлэг шинжтэй байсны илрэл юм.

Нийгмийн цорын ганц институт байсан төр иргэнтэйгээ харилцах харилцаандаа хүмүүнлэг зарчмыг баримтлахын зэрэгцээ иргэд хоорондоо харилцан туслалцах харилцааг нь хуульчлан зохицуулж өгсөн байна. Энэ тухай мөнөөх Л.Н.Гумилев "нөхөртөө тусалсангүй гэж шийтгэдэг хуультай улс монголоос өөр байсангүй" гэж "Хар домог"-тоо тэмдэглэсэн байдаг.

1990-ээд оноос хойш монголд нийгмийн хүмүүнлэг харилцааны тухай, нийгмийн ажил гэдэг "шинэ" мэргэжлийн тухай ярьж эхэлсэн нь угтаа мартагдсан хуучин зүйлийн тухай байв. Тэр үеэс хойш нийгмийн ажлыг шинээр хөгжүүлэх талаар багагүй зүйл хийж байгаа боловч түүнийг шинжлэх ухаантай холбох, хөгжингүй нийгмийн боловсронгуй тогтолцооноос суралцах чиглэл нь түрүүлэх хандлагатай байхад уламжлалд суурилах талаар тун хангалтгүй байгаа юм. Энэ нь К.Попперийн нэгэнтээ дурьдсанаар "сэтгэлзүйгээс хамгийн хол хөндий" марксизм гэдэг онолоор нийгмээ танин мэдэж тайлбарлах гэж оролдож ирсэнтэй ихээхэн холбоотой боловуу. Өөрөөр хэлбэл ХХ зууны өндөрлөгт монголын уламжлалт нийгэмд гарсан өөрчлөлтийг марксист онол аргагүйгаар шинжин судлахдаа сэтгэлзүй ёс суртахуун хүмүүнлэгийн хүрээнд юу олж, юуг алдсанаа өнөө болтол огт анхаарч байгаагүйтэй холбоотой.

Эхэлж буй энэ зууны даяарчлалын давалгаанд татагдан ороход өмнөх зууны иргэншил, эдүгээчлэлийн сургамж туршлага үнэ цэнэтэй болохын учир атраараа орхигдсон энэ мэт сэдэв рүү идэр оюуны анхаарал хандана гэдэгт итгэлтэй байна.